



## “ЦАХИМ ЭРИНД ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО” АЯНЫ ТАЙЛАН

### **Нэг. Шаардлага**

Монголбанкны Ерөнхийлөгчийн санаачлагаар 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 21-ний өдрийг хүртлэх 2 сарын хугацаанд зарлан явуулсан “Цахим эринд цахим төлбөр тооцоо” аяны хүрээнд Төлбөр тооцооны газраас зохион байгуулсан ажил, хэрэгжүүлсэн арга хэмжээг нэгтгэж тайлагнахаар энэхүү танилцуулгыг бэлтгэлээ.

### **Хоёр. Аяны зорилго, хамарсан хүрээ**

Тус аян нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх, Монгол Улс дахь төлбөрийн системийн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, ирээдүйн хөгжлийн талаар олон нийтэд таниулан сурталчлах, иргэд, хэрэглэгчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилготой байсан.

Аяны хугацаанд дараах үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулсан:

1. Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримталж буй бодлого, үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги, хууль, эрх зүйн орчныг нийтэд үнэн зөв, ойлгомжтой байдлаар тайлбарлах, таниулах;
2. Цахим төлбөрийн үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамаарч түргэн шуурхай гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх боломжтой финтек хөгжлийг дэмжих;
3. Бэлэн бус төлбөр тооцооны талаарх олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх;
4. Төлбөрийн системийн оролцогчдын хамтын ажиллагааг дэмжих.

Аяны үйл ажиллагаанд Монголбанк, түүний орон нутаг дахь салбарууд, банкууд, Сангийн Яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо, Үндэсний төлбөрийн системийн гишүүн байгууллага, цахим гарын үсгийн төслийг хэрэгжүүлэгч байгууллага, АХБ-ны “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн нэгж, Улаанбаатар TEDx-тэй хамтран ажиллалаа.

### **Гурав. Аяны хүрээнд хийгдсэн ажлуудын товч**

ТТГ нь Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

*1. Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийг байгуулж, анхдугаар хуралдааныг зохион байгуулсан:*

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар үндэсний төлбөрийн системийн оролцогчийг хамарсан зөвлөлийг байгуулж, дүрмийг баталсан. Зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр гишүүн 26 байгууллагын оролцоотойгоор зохион байгуулсан. Хуралдаанаар Зөвлөлийн дүрэм, Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа,

бодлого зохицуулалтын талаар, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монголбанкнаас хэрэгжүүлж буй "Төлбөрийн системийн шинэчлэл" төслийн хүрээнд төлбөрийн системийн дэд бүтцийг сайжруулах, олон улсын жишигт нийцсэн програм, техник хангамжийг нэвтрүүлэхэд чиглэсэн ажлуудыг танилцуулсан. Мөн МБХ-оос илтгэл хийж, хэлэлцүүлэгт оролцсон. Зөвлөлийн хуралдаанд цахим мөнгөний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ын төлөөлөл анх удаа оролцсон нь онцлог үйл явдал байлаа.

## *2. “Дижитал гарц” өдөрлөгийг зохион байгуулсан:*

Монголын банкны холбоо, банкууд, финтекийн төлөөлөлтэй хамтран “Дижитал гарц өдөрлөг”-ийг 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Туушин зочид буудалд зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр TEDx Улаанбаатар байгууллагатай хамтран “Дижитал гарц” сэдвээр банк, финтек, мэдээллийн технологийн салбарын төлөөлөл оролцож илтгэл хийж, шинэлэг санаа дэвшилтэд хөгжлийн тухай бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд нээлттэй танилцуулсны зэрэгцээ мэдээллийн технологийн хөгжилтэй зэрэгцэн төлбөрийн системд нэвтэрч буй шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүргэж чадсан үр өгөөжтэй үйл ажиллагаа болсон. Тухайлбал, “Дижитал гарц өдөрлөг”-ийн үеэр Төрийн банкны 9 жилийн ой тохиосон тул цахим банк ашиглаж төлбөр тооцоо хийсэн 9 азтаныг шалгаруулж гарын бэлэг, дурсгалын зүйлсийг гардуулсан. Ариг банк цахим банк үнэгүй нээх эрх, Худалдаа хөгжлийн банк, Богд банк, Ариг банк карт үнэгүй захиалах эрхийг өгч урамшуулсан.

## *3. Эссе бичлэгийн уралдаан зарлаж, дүгнэсэн:*

Монголбанкнаас энэхүү аяны хүрээнд оюутан, залуучууд, иргэдийн дунд “Цахим төлбөр тооцооны хэрэглээ” сэдэвт эссе бичлэгийн уралдаан зарласан бөгөөд нийт 60 гаруй оюутан, залуус эссе бичлэгээ ирүүлсэн. Эссе бичлэгүүдэд төлбөр тооцооны үйлчилгээний дэвшил, шинэ үйлчилгээ нь иргэд олон нийтийн өдөр тутмын хэрэглээг хөнгөвчилж, цагийг хэмнэж, хөгжил дэвшлийг дагуулж байдаг тул иргэд олон нийтээс нилээд чухал ач холбогдол өгч судалж, суралцаж байдаг. Иймд төлбөр тооцоо гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтийн жишигт нийцүүлж байх гэсэн нийтлэг үзэл санааг дурдсан байлаа. Өдөрлөгийн үеэр эдгээр оролцогчдоос шилдэг эссе шалгаруулж, тэргүүн байр эзэлсэн оролцогчдод Монголбанкны зүгээс дурсгалын зүйл, шагналыг гардуулсан.

## *4. Үндэсний төлбөрийн системд одоо мөрдөж буй журам, дүрэм, заавар, тулгамдаж буй асуудал, цаашид хийгдэх ажлуудыг танилцуулсан нээлттэй сургалтыг зохион байгуулсан:*

Төлбөрийн системийн үйл ажиллагаа, түүнд мөрдөгдөж байгаа хууль, журмын талаар нийтэд танилцуулах зорилгоор 2018 оны 12 дугаар сарын 6-ны өдөр олон нийтэд нээлттэй сургалт зохион байгуулсан. Сургалтад банкууд, төлбөрийн болон клирингийн үйлчилгээ эрхлэх сонирхолтой байгууллагууд, ББСБ, хуулийн фирмын төлөөлөл болон иргэд оролцсон.

Сургалтын үеэр ТТГ-ын Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн мэргэжилтнүүд одоогийн мөрдөж байгаа хууль, журмыг хялбаршуулсан хэлбэрээр тайлбарлаж холбогдох санал, сэтгэгдэл сонсож, асуултад хариулж, олон нийтэд төлбөрийн системийн талаарх мэдлэг, мэдээллийг цогц байдлаар олгосон нийтийн эрх ашиг, эрэлт хэрэгцээг хангасан нилээд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Сургалтын илтгэлийг дараах сэдвээр дэлгэрэнгүй байдлаар таниулан тайлбарласан нь илүү үр өгөөжтэй байлаа. Үүнд:

- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль
- Монголбанкнаас шинээр баталсан Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам
- Их дүнтэй төлбөрийн системийн шинэчилсэн журам
- Цахим мөнгөний журам
- Бага дүнтэй төлбөрийн системийн журам

Сургалтанд оролцогчдын зүгээс тус сургалтыг тогтмол явуулж өгөх хүсэлтийг гаргасан тул ТТГ-аас Банкны хөгжил-95 аяны хүрээнд дахин сургалт хийхээр төлөвлөж байна.

*5.₮ картыг EMV чип технологид шилжүүлэхээр ажиллаж байна:*

Үндэсний төлбөрийн ₮ картыг EMV чип технологид шилжүүлэх ажлын хүрээнд олон улсын төлбөрийн картын үйл ажиллагаа эрхэлдэг VISA байгууллагатай хамтран ажиллах шийдвэрийг Монголбанкны удирдлага 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдөр гаргасаныг төлбөрийн системийн оролцогч байгууллагуудад зарлан мэдэгдсэн. Энэхүү шийдвэр нь Монгол Улсын төлбөрийн системд тухайлбал, төлбөрийн картын хөгжилд бас нэгэн дэвшилтэд алхам болсон гэж үзэж байна.

*6.PKI буюу цахим гарын үсгийн системийг ашиглах боломжтой болсон:*

PKI буюу цахим гарын үсгийн системийг хөгжүүлэгч байгууллага Тридиум компаниас 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авлаа. Энэхүү системийг Монголбанкны дотоод системүүд, төлбөр тооцооны бүх систем, банк болон банк бус байгууллагаас зээлийн мэдээллийн санд хандах, Төв банкны үнэт цаас болон валютын арилжаа, банк хоорондын цахим арилжааны системүүдэд ашиглахыг зорьж байна. Ингэснээр энэхүү дэд бүтцийг ашиглан, банк, санхүүгийн байгууллагууд нэмэлт хөрөнгө оруулалт хийхгүйгээр дотоод системдээ шууд ашиглах боломж бүрдэнэ.

*7.Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг Төрийн банктай хамтран хэрэгжүүлсэн.*

Иргэд төрийн үйлчилгээний шимтгэл, хураамж, төлбөр төлөхийн тулд банкин дээр дараалал үүсгэж, цаг хугацаа алдаж, бухимдаж байсан хүндрэлийг арилгах зорилгоор Нийслэлийн мэдээллийн технологийн газар, Төрийн банктай хамтран Төрийн үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээнд ПОС төхөөрөмж байршуулж, төлбөр тооцоог 24/7 горимоор, 1-4 секундний дотор гүйцэтгэдэг болголоо. Энэхүү Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр албан ёсоор нээсэн бөгөөд төрийн 47 үйлчилгээны төлбөр тооцоог цахимаар хийх боломжтой болсон.

*8. Олон нийтийг хүртээмжтэй мэдээ, мэдээллээр хангаж, санхүүгийн боловсролыг дэмжиж ажилласан:*

1. Монголбанкны орон нутгийн хянан шалгагч, нягтлан бодогч нарыг Төлбөрийн системийн талаар сургалтанд хамруулсны дагуу орон нутагт төлбөрийн системийн талаарх сургалтыг зохион байгуулсан.

2. Энэхүү аяны хүрээнд нийт банк, санхүүгийн 23 байгууллагаас хийсэн ажлын тайланг 14 хоног тутамд авч нэгтгэлээ. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих, төлбөрийн хэрэгслийг таниулах, хамтын ажиллагааг дэмжих, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага финтекийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд төлбөрийн

системийн оролцогч төдийгүй олон нийт, иргэдэд нээлттэй, хүртээмжтэй ажлыг хийсэн байна. Тухайлбал:

- сошиал медиа сувгуудаар банк, санхүүгийн байгууллагын үзүүлж буй цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээллийг хүргэсэн;
- иргэдэд цахим төлбөр тооцоог хэрхэн аюулгүй хийх талаар, онлайн худалдаанд хэрхэн ашиглах, төлбөрийн хэрэгслийн нууц үгийг алдахгүй байх мэдээлийг түгээсэн;
- цахим банкны хэрэглээ, ач холбогдлын талаар гарын авлага, хэвлэмэл хуудас тараасан;
- олон нийтэд цахим төлбөр тооцооны ач холбогдол, түргэн шуурхай байдал, заавал банкин дээр биеэр очихгүйгээр банкны үйлчилгээ авах боломжуудыг хэрхэн ашиглах талаар зөвлөмж, зөвлөгөөг өгсөн;
- Монголын радио, телевизээр төлбөр тооцооны нууцлал аюулгүй байдлын тухай, хэрэглээний талаар мэдээлэл, ярилцлагыг өгөх ажлыг хэрэгжүүлжээ.

3. Төлбөрийн системийн оролцогчдоос ирүүлсэн тайлангаас үзэхэд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна:

- цахим төлбөрийн үйлчилгээг түргэн шуурхай гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс Баян-Өлгий аймаг дахь Хаан банкны салбар Теллергүй өдөр, Орхон аймаг дахь Төрийн банкны салбар Qpay буюу QR кодын тусламжтайгаар гүйлгээ хийх өдрийг зарлан хэрэгжүүлжээ. Ингэснээр данс эзэмшигчийн дансны дугаар болон харилцагчийн нэрийг оруулах шаардлагагүй бөгөөд банк хоорондын гүйлгээ хийхэд амар, хялбар, данс андуурч гүйлгээ хийхээс урьдчилан сэргийлдэг талаар сурталчилсан байна. Орхон аймаг дахь Голомт банкны салбар Social Pay буюу бүх төрлийн хадгаламжийн үйлчилгээ, Үндэсний хуримтлал, Интернэт банк үйлчилгээ, Mobile bank, Social pay үйлчилгээ, олон улсын болон дотоодын карт, кредит картын үйлчилгээний талаар танилцуулга хийсэн байна. Голомт банкнаас ХААИС, ШУТИС, СЭЗИС, АШУҮИС дээр цахим төлбөр тооцооны талаар мэдээлэл өгөх зорилготой “Digital wave dance battle” өдөрлөгийг амжилттай зохион байгуулжээ.
- Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банк, Голомт банк, Хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Увс аймаг дахь Хас банкны салбар, Хаан банкны салбар, Төрийн банкны салбар, Капитал банкны салбар, Баян-Өлгий аймаг дахь Төрийн банкны салбар, Хас банкны салбар, Орхон аймаг дахь Капитрон банкны салбар, Хас банкны салбар, Худалдаа хөгжлийн банкны салбар, Голомт банкны салбар, Монголбанкны Ховд аймгийн салбар, Баянхонгор аймаг дахь салбар, Өмнөговь аймаг дахь салбар, Дорнод аймаг дахь салбар, Увс аймаг дахь салбар, Завхан аймаг дахь салбар, Орхон аймгийн салбарууд бэлэн бус төлбөр тооцоог дэмжих, ажилтнууд болон харилцагчийг дэлгэрэнгүй мэдээллээр хангахын тулд тэнхимийн болон зайн сургалтуудыг зохион байгуулсан байна.
- КУБ-ын эрсдэлээс сэргийлэх, ПОС-ын гүйлгээг эрсдэлгүй гүйцэтгэх зааварчилгаа өгөх сургалтуудыг тогтмол зохион байгуулах зэрэг ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна.
- ТТГ-ын зүгээс аяны хугацаанд 4 ярилцлага, 9 видео бичлэг, өдөрлөгтэй холбоотой 10 гаруй мэдээ мэдээлэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, нийтийн сүлжээгээр түгээсэн байна. Монголбанкны цахим хуудсанд Цахим эринд Цахим

төлбөр тооцоо аяны цэс шинээр оруулж, мэдээ мэдээлэл ярилцлага, видео, боршур зэргийг цахим сүлжээнд идэвхтэй түгээсэн. Мөн хэвлэлийн мэдээ, ярилцлага, нийтлэл зэргийг олон нийтэд хүртээмжтэй цагаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон Монголбанкны орон нутаг дахь салбар банкаараа дамжуулан нийтэд хүргэсэн байна.

## **Дөрөв. Дүгнэлт**

Тус аяны үеэр санхүүгийн үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн технологийн хурдацтай хөгжилд тулгуурлан төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх, шинэ үйлчилгээг сурталчлах арга хэмжээг амжилттай зохион байгуулсан нь бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэх Монголбанкны бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.

Мөн Монгол Улсын үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, ирээдүйн хөгжлийн талаар олон нийтэд таниулан сурталчилсан нь иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Аяныг хэрэгжүүлснээр нэг талаас иргэд, харилцагч Монгол Улсын үндэсний төлбөрийн систем, финтекийн хөгжил, бэлэн бус төлбөрийн хэрэгсэл, цахим төлбөр тооцооны талаар нэгдсэн ойлголтод хүрч, нөгөө талаас төлбөрийн системийн оролцогч хоорондын үйл ажиллагаа идэвхжиж, хамтын ажиллагааг бэхжихэд дэмжлэг болсон гэж дүгнэж байна.

---oOo---